

Харилцаа холбооны зохицуулах хорооны даргын
..... оны дугаар сарын-ний өдрийн
..... дугаар тушаалын хавсралт

САНСРЫН ХОЛБООНЫ СҮЛЖЭЭ, ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧИЙН МЭДЭЭ 3- СХСҮ МАЯГТ НӨХӨХ ЗААВАР

Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн хүрээнд **Сансрын холбооны сүлжээ, үйлчилгээ** эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллага нь Харилцаа холбооны зохицуулах хорооноос баталсан “Харилцаа холбооны зах зээлд шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх журам”-ын 4.3-д заасны дагуу өөрийн үйл ажиллагаатай холбоотой тухайн жилийн тайлан, мэдээг дараа оны 02 дугаар сарын 20-ны дотор, хагас жилийн тайлан, мэдээг тухайн оны 08 дугаар сарын 01-ний дотор маягтад тодорхойлсон үзүүлэлтийн дагуу <http://statistics.crc.gov.mn> хаягаар цахим программд шивж, Зохицуулах хороонд ирүүлнэ.

***Тайлант хугацаа** гэж жилийн эцсийн тайлан, мэдээний хувьд өмнөх оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацааг, хагас жилийн тайлан, мэдээний хувьд тухайн жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 06 дугаар сарын 30-ны өдрийг хүртэлх хугацааг ойлгоно.*

МАЯГТЫН НЭР ТОМЪЁО, ТОВЧЛОЛЫН ТАЙЛБАР

***НДШ** гэж нийгмийн даатгалын шимтгэлд төлсөн нийт дүнг ойлгоно.*

***ААНОАТ** гэж аж ахуйн нэгжийн орлогын албан татварт төлсөн нийт дүнг ойлгоно.*

***НӨАТ** гэж нэмэгдсэн өртгийн албан татварт төлсөн нийт дүнг ойлгоно.*

***ХХОАТ** гэж хувь хүний орлогын албан татварт төлсөн нийт дүнг ойлгоно.*

***БНҮҮ сан** гэж тайлант хугацаанд бүх нийтийн үүргийн санд төвлөрүүлсэн хөрөнгийн хэмжээг ойлгоно.*

***Газрын станц (Hub station)** гэж сансрын холбооны системийн газарт байрлах төхөөрөмж болон дэд бүтцийг илэрхийлдэг. Энэ станц нь хиймэл дагуултай өгөгдөл болон яриаг солилцох үндсэн гол холбоос болдог бөгөөд хэрэглэгчийн төхөөрөмжөөс ирсэн сигнал, мэдээллийг хүлээн авч, боловсруулан дамжуулдаг.*

***GEO (Geostationary Earth Orbit)** гэж Сансрын геостационар тойрог зам буюу дэлхийгээс ~35,786 км орчим зайд байрлах, дэлхийн экваторын дагуу дэлхийтэй нэг хурдаар эргэж, тогтмол байрлалтай харагддаг хиймэл дагуулын системийн тойрог зам*

***LEO (Low Earth Orbit)** гэж дэлхийгээс 160–2,000 км зайд, дэлхийг хурдан тойрдог (~90– 120 минут), доогуур байрлалтай, бага хоцрогдолтойгоор мэдээлэл дамжуулах боломж бүрдүүлсэн сансрын холбооны дэвшилтэт системийн тойрог зам.*

VSAT (Very Small Aperture Terminal) гэж тухайн GEO хиймэл дагуултай холбогдох хурдан, найдвартай газар дээрх жижиг антентэй хүлээн авах төхөөрөмж.

VPN (Virtual Private Network) гэж хувийн (жишээ нь байгууллагын салбар хооронд), аюулгүй, төгсгөлийн төхөөрөмж хоорондын сүлжээний холболтыг бий болгодог систем.

I. ХАЯГИЙН ХЭСЭГ

Тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллагын нэр, регистрийн дугаарыг улсын бүртгэлийн гэрчилгээнд тусгагдсанаар товчлохгүйгээр нөхнө. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн оршин байгаа байшин, байр, баг, хороо, сум, дүүрэг, аймаг, нийслэлийн нэрийг бичиж, Монгол Улсын засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн кодоос тохирох кодыг тус тус нөхнө.

Тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллагын утасны дугаар, цахим шуудангийн хаяг болон тайлан, мэдээг хариуцан бөглөх ажилтны овог нэр, албан тушаал, утасны дугаар, цахим хаягийг тус тус нөхнө.

II. ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

БАГАНА Г: ХХЗХ-ны даргын 2022 оны А/335 дугаар тушаалаар батлагдсан “Тусгай зөвшөөрөл эзэмшигчээс мэдээ, тайлан бүрдүүлэх, түгээхэд баримтлах журмын 9.2-т заасны дагуу “Н1- Нууц гэж үзэх ба ийм тэмдэглэл бүхий үзүүлэлтийг Зохицуулах хороо зөвхөн өөрийн үйл ажиллагаанд ашиглана.”, “Н2- Нээлттэй мэдээлэл гэж үзэх ба аж ахуйн нэгжийг дурдаж, нийтэд мэдээлж болно.”

БАГАНА 1: Тухайн үзүүлэлтийн утгыг нөхнө. Ингэхдээ хэмжих нэгж тус бүрийг нягтлах.

БАГАНА 2: Тухайн үзүүлэлт тус бүрд нэмэлт тайлбар, тодруулга бичиж тэмдэглэх шаардлагатай тохиолдолд тэмдэглэлийг тусгана.

САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Санхүүгийн үзүүлэлт хэсэг нь Дүрмийн сангийн хэмжээ, Нийт орлого, Нийт зардал, Нийт хөрөнгө оруулалт, Нийт төсөвт төвлөрүүлсэн орлого хэсгүүдээс бүрдэнэ.

МӨРИЙН ДУГААР:1 Дүрмийн сангийн хэмжээ мөрөнд тайлант хугацааны байдлаар компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ буюу санхүүгийн тайлан дахь өмчийн дүнг бичнэ. Дүрмийн сангийн хэмжээ буюу 1 дүгээр мөрийн дүн нь 2-оос 6 дугаар мөрүүдийн нийлбэр дүнтэй тэнцүү байна.

МӨРИЙН ДУГААР:2 Төрийн- Төрийн өмчийн, төрийн өмчийн оролцоотой эсхүл төрийн хамтарсан аж ахуйн нэгж бол энд дүрмийн сан дахь төрийн өмчийн тохирох дүнг нөхнө.

МӨРИЙН ДУГААР:3 Орон нутгийн- Орон нутгийн өмчийн, Орон нутгийн өмчийн оролцоотой эсхүл орон нутгийн хамтарсан аж ахуйн нэгж бол энд дүрмийн сан дахь өмчийн тохирох дүнг нөхнө.

МӨРИЙН ДУГААР:4 Хувийн, Монгол Улсын- Дүрмийн сан дахь Монгол Улсын хувийн өмчийн дүнг нөхнө.

МӨРИЙН ДУГААР:5 Хувийн, гадаадтай хамтарсан- Гадаадын аж ахуйн нэгжтэй хамтарсан аж ахуйн нэгж бол дүрмийн сан дахь гадаад талын өмчийн дүнг нөхнө.

МӨРИЙН ДУГААР:6 Гадаад улсын- Гадаад улсын хөрөнгө оруулалттай бол гадаад улсын өмчийн дүнг нөхнө.

МӨРИЙН ДУГААР:7 Нийт орлогын хэмжээ мөрөнд тайлант хугацаанд тусгай зөвшөөрлийн хүрээнд сансрын холбооны сүлжээ, үйлчилгээнээс олсон нийт орлогын дүнг бичнэ. *Нийт орлого буюу 7 дугаар мөрийн дүн нь 8-аас 13 дугаар мөрүүдийн нийлбэр дүнтэй тэнцүү байна.*

МӨРИЙН ДУГААР:8 Сувгийн түрээсийн үйлчилгээ мөрөнд дамжуулах сүлжээний зориулалтаар сансрын холбооны сувгийг түрээслүүлж олсон (тухайлбал үүрэн холбооны операторуудад дамжуулах сүлжээний зорилгоор түрээсэлж байгаа) сүлжээний үйлчилгээний орлогын дүнг бичнэ.

МӨРИЙН ДУГААР:9 Байгууллагын хувийн сүлжээ (VPN) зохион байгуулах үйлчилгээ мөрөнд сансрын холбооны сувгийг байгууллагын дотоод сүлжээ (VPN)-ний зорилгоор зохион байгуулах үйлчилгээ үзүүлсэн орлогын дүнг бичнэ.

МӨРИЙН ДУГААР:10 Интернэтийн үйлчилгээ мөрөнд жижиглэнгийн үйлчилгээ буюу эцсийн хэрэглэгчид (үүнд байгууллагын болон өрхийн хэрэглэгч аль аль нь хамаарна) үзүүлсэн интернэтийн үйлчилгээний орлогын дүнг бичнэ.

МӨРИЙН ДУГААР:11 Ярианы үйлчилгээ (телефон утас) мөрөнд жижиглэнгийн үйлчилгээ буюу эцсийн хэрэглэгчид (үүнд байгууллагын болон өрхийн хэрэглэгч аль аль нь хамаарна) үзүүлсэн ярианы үйлчилгээний орлогын дүнг бичнэ. Энд нийтийн интернэтээр дамжуулсан ярианы үйлчилгээ хамаарахгүй.

МӨРИЙН ДУГААР:12 Багцын үйлчилгээ (яриа интернэт хосолсон) мөрөнд жижиглэнгийн үйлчилгээ буюу эцсийн хэрэглэгчид (үүнд байгууллагын болон өрхийн хэрэглэгч аль аль нь хамаарна) үзүүлсэн яриа, интернэт хосолсон үйлчилгээний орлогын дүнг бичнэ.

МӨРИЙН ДУГААР:13 Бусад орлого мөрөнд дээрх ангилалд ороогүй, тусгай зөвшөөрлийн хүрээнд үзүүлсэн бусад үйлчилгээний орлогын дүнг бичнэ.

МӨРИЙН ДУГААР:14 Нийт зардал мөрөнд тайлант хугацаан дахь сансарын холбооны сүлжээ, үйлчилгээтэй холбоотой нийт зардлын дүнг бичнэ. *Нийт зардал буюу 14 дүгээр мөрийн дүн нь 15-аас 21 дүгээр мөрүүдийн нийлбэр дүнтэй тэнцүү байна.*

МӨРИЙН ДУГААР:16 Интернэтийн гарцын төлбөр мөрөнд интернэтийн үйлчилгээ үзүүлдэг тохиолдолд тайлант хугацаанд интернэтийн бөөний үйлчилгээ үзүүлэгчид төлсөн төлбөрийн дүнг бичнэ.

Судалгаа, шинжилгээний ажлын зардал гэж байгууллагын бүх төрлийн үйл ажиллагаа, үйлчилгээний чанарыг сайжруулах, шинээр бүтээгдэхүүн үйлчилгээ нэвтрүүлэх, урт ба богино хугацааны төлөвлөгөө боловсруулахад тусгайлан төсөвлөж зарцуулсан зардлыг ойлгоно.

МӨРИЙН ДУГААР:22 Нийт хөрөнгө оруулалт мөрөнд тайлант хугацаанд сансрын холбооны сүлжээ, үйлчилгээнд оруулсан хөрөнгө оруулалтын дүнг бичнэ. *Нийт хөрөнгө оруулалт буюу 22 дугаар мөрийн дүн нь 23-аас 26 дугаар мөрүүдийн нийлбэр дүнтэй тэнцүү байна.*

МӨРИЙН ДУГААР:27 Төсөвт төвлөрүүлсэн орлого мөрөнд тайлант хугацаанд сансрын холбооны сүлжээ, үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой нийт төсөвт төвлөрүүлсэн орлогын хэмжээг буюу ажиллах хүчний нийгмийн даатгалын шимтгэл (НДШ), ААНОАТ, НӨАТ, ХХОАТ, импортоор орж ирсэн бараа материал, тоног төхөөрөмжийн гаалийн татварын дүн, Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан (БНҮҮС)-д төвлөрүүлсэн хөрөнгө болон бусад төрлийн татвар, хураамжийн нийлбэр дүнг бичнэ. *Нийт төсөвт төвлөрүүлсэн орлого буюу 27 дугаар мөр нь 28-аас 34 дүгээр мөрүүдийн нийлбэр дүнтэй тэнцүү байна.*

ХҮНИЙ НӨӨЦИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Хүний нөөцийн үзүүлэлт хэсэг нь нийт ажиллагчдын тоо, ажиллагчдыг нас, хүйс, боловсролын түвшин, мэргэжил, албан тушаалаар ангилсан тоо, дундаж цалингийн үзүүлэлтээс бүрдэнэ.

МӨРИЙН ДУГААР:35 Нийт ажиллагчдын тоог бөглөхдөө сансрын холбооны сүлжээ, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаанд оролцож, хөдөлмөр эрхлэлтийн аль нэг статуст хамрагдаж буй нийт ажилтныг хамруулна. Цалин хөлс, орлого олох зорилгоор эдийн засгийн үйл ажиллагаанд сүүлийн долоо хоногт нэгээс дээш цагаар оролцсон ажиллагчдыг багтаана.

Нийт ажиллагчдын тоо буюу 35 дугаар мөр нь 36-аас 45 дугаар мөр дэх насны бүлгээр 6-аас 47 дугаар мөр дэх хүйсээр, 48-аас 56 дугаар мөр дэх боловсролын түвшинээр, 57-аас 66 дугаар мөр дэх ажил мэргэжлээр, 67-аас 73 дугаар мөр дэх албан тушаалаар ангилсан ажиллагчдын тооны нийлбэртэй тус тус тэнцүү байна.

(ОУЦХБ-ын аргачлалын дагуу Full Time Employee – FTE буюу бүтэн цагийн ажилтай ажилтны тоо байна. Бүтэн бус цагийн ажилтай ажилтнуудыг 8 цагийн ажлын өдрөөр дүйцүүлж, бүтэн цагийн ажилтай ажилтанд шилжүүлж тооцно.

ҮСХ заавар: Нийт ажиллагчдын тоо гэдэгт цалин хөлс, орлого олох зорилгоор эдийн засгийн үйл ажиллагаанд оролцож, хөдөлмөр эрхлэлтийн аль нэг статуст хамрагдаж буй иргэдийг хамруулна. Цалин хөлс, орлого олох зорилгоор эдийн засгийн үйл ажиллагаанд сүүлийн долоо хоногт нэгээс дээш цагаар оролцсон ажиллагчдыг багтаана.)

Ажиллагчдын мэргэжлийн байдал нь албан тушаалтай хамааралгүй бөгөөд ажилтны эзэмшсэн мэргэжлийн код ангиллын дагуу тоог гаргана. Албан тушаалын ангиллыг өөрийн байгууллагын бүтэц, ажлын байрны нэршилд дүйцүүлэн ойлгож, бөглөнө.

МӨРИЙН ДУГААР:74-81 Дундаж цалин, албан тушаалаар- Харгалзах албан тушаалын ажиллагчдын нийт цалинг харгалзах албан тушаалтнуудын тоонд харьцуулж гаргана.

СҮЛЖЭЭ, ДЭД БҮТЦИЙН МЭДЭЭЛЭЛ

МӨРИЙН ДУГААР:82 Газрын станцын тоо (Hub station) мөрөнд сансрын холбооны үйлчилгээ үзүүлэх зорилгоор Монгол Улсын газар нутагт байгуулсан өөрийн газрын станцын нийт тоог бичнэ.

МӨРИЙН ДУГААР:83 VSAT цэгийн тоо (Remote station) мөрөнд сансрын холбооны үйлчилгээ авсан хэрэглэгчийн нийт VSAT цэгийн тоог бичнэ.

МӨРИЙН ДУГААР:84 Сансрын холбооны сүлжээний багтаамж (транспондерийн хэмжээ) мөрөнд гэрээлсэн транспондерийн зурвасын хэмжээг нөхнө.

МӨРИЙН ДУГААР:85-86 Сансрын холбооны сүлжээний багтаамж, чиглэлээр мөрөнд багтаамжийг нэвтрүүлэх (Uplink) болон хүлээн авах (Downlink) чиглэлээр ялган гаргаж нөхнө.

МӨРИЙН ДУГААР:87-90 Сансрын холбооны сүлжээний багтаамж, үйлчилгээний төрлөөр мөрөнд сансрын холбооны сүлжээний багтаамжийг аль үйлчилгээнд ашиглагдаж байгаагаар ангилан бичнэ.

МӨРИЙН ДУГААР:87 Харилцаа холбооны суваг түрээсийн үйлчилгээнд мөрөнд дамжуулах сүлжээний зориулалтаар (бөөний үйлчилгээнд) ашиглаж байгаа багтаамжийг бичнэ.

МӨРИЙН ДУГААР:88 Байгууллагын дотоод сүлжээний үйлчилгээнд (VPN) мөрөнд байгууллагын дотоод сүлжээ (VPN)-ний үйлчилгээнд ашигласан багтаамжийг бичнэ.

МӨРИЙН ДУГААР:89 Яриа, интернэтийн үйлчилгээнд мөрөнд жижиглэнгийн (retail) үйлчилгээ буюу эцсийн хэрэглэгчид (үүнд байгууллагын болон өрхийн хэрэглэгч аль аль нь хамаарна) үзүүлсэн яриа, интернэтийн үйлчилгээнд ашигласан багтаамжийг бичнэ.

МӨРИЙН ДУГААР:91-95 Сансрын холбооны сувгийн түрээсийн үйлчилгээний гэрээтэй харилцагч байгууллагын нийт тоо мөрөнд сувгийн түрээсийн гэрээ байгуулсан харилцагч байгууллагын тоог үйлчилгээний төрлөөр нь ялган гаргана.

ХЭРЭГЛЭГЧИЙН ТОО

МӨРИЙН ДУГААР:96 Сансрын холбооны үйлчилгээний нийт идэвхтэй хэрэглэгчийн тоог бөглөхдөө сансрын холбооны үйлчилгээ авч буй идэвхтэй хэрэглэгчид буюу сарын суурь хураамж төлж буй эсхүл сард хамгийн багадаа нэг удаа яриа хийсэн эсхүл интернэтэд холбогдсон хэрэглэгчийг хамруулна. Энд сувгийн түрээсийн үйлчилгээ, байгууллагын дотоод сүлжээний үйлчилгээ авч буй харилцагчийг оруулахгүй. *Сансрын холбооны үйлчилгээний нийт идэвхтэй хэрэглэгчийн тоо буюу 96 дугаар мөрийн дүн нь 97-оос 100 дугаар мөрүүдийн нийлбэр дүнтэй тэнцүү байна.*

МӨРИЙН ДУГААР:97 GEO, (Iridium, Inmarsat, Thuraya г.м) хэрэглэгч мөрөнд хиймэл дагуулын геостационар тойрог замд ажилладаг Иридиум, Инмарсат, Тураяа зэрэг үйлчилгээний сансрын гар утасны үйлчилгээ үзүүлдэг бол тэдгээр хэрэглэгчийн тоог бичнэ.

МӨРИЙН ДУГААР:98 GEO, VSAT хэрэглэгч мөрөнд геостационар тойрог замын хиймэл дагуулын VSAT систем ашиглаж буй гэрээт хэрэглэгчийн тоог бичнэ.

МӨРИЙН ДУГААР:99 LEO хэрэглэгч мөрөнд нам орбитын хиймэл дагуулын үйлчилгээний гэрээт хэрэглэгчийн тоог бичнэ.

МӨРИЙН ДУГААР:101 Сансрын холбооны ярианы үйлчилгээний нийт идэвхтэй хэрэглэгчийн тоог бөглөхдөө сүүлийн 3 сарын дотор төлбөрөө төлж, телефон ярианы үйлчилгээ авч буй хэрэглэгчийн тоог нөхнө. *Сансрын холбооны ярианы үйлчилгээний нийт идэвхтэй хэрэглэгчийн тоо буюу 101 дүгээр мөр нь 102-оос 104 дүгээр мөр дэх байршлаар, 105- аас 106 дугаар мөр дэх төрлөөр, 107-оос 108 дугаар мөр дэх гэрээний төрлөөр ангилсан сансрын холбооны ярианы үйлчилгээний нийт идэвхтэй хэрэглэгчийн тооны нийлбэртэй тус тус тэнцүү байна.*

МӨРИЙН ДУГААР:102 Улаанбаатар хотын хэрэглэгчийн тоо нь Улаанбаатар хотын бүх дүүргийн телефон ярианы хэрэглэгчийн тооны нийлбэртэй тэнцүү байна.

МӨРИЙН ДУГААР:103 Аймгийн төвийн хэрэглэгчийн тоо нь аймгийн төвүүд дэх телефон ярианы хэрэглэгчийн тооны нийлбэртэй тэнцүү байна.

МӨРИЙН ДУГААР:104 Сумын хэрэглэгчийн тоо нь сумуудын телефон ярианы хэрэглэгчийн тооны нийлбэртэй тэнцүү байна. Сумын хэрэглэгчид аймгийн төвийн хэрэглэгчийг оруулахгүй.

Аймгийн төв болон сумын хэрэглэгчийн тооны нийлбэр нь орон нутгийн хэрэглэгчийн тоо болно.

МӨРИЙН ДУГААР:109 Сансрын холбооны өргөн зурвасын интернэтийн идэвхтэй хэрэглэгчийн тоог бөглөхдөө сансрын холбооны үйлчилгээ авч буй идэвхтэй хэрэглэгчид буюу сарын суурь хураамж төлж буй эсхүл сард хамгийн багадаа нэг удаа интернэтэд холбогдсон хэрэглэгчийг хамруулна.

МӨРИЙН ДУГААР:110 Улаанбаатар хотын хэрэглэгчийн тоо нь Улаанбаатар хотын бүх дүүргийн интернэт хэрэглэгчийн тооны нийлбэртэй тэнцүү байна

МӨРИЙН ДУГААР:111 Аймгийн төвийн хэрэглэгчийн тоо нь аймгийн төвүүд дэх интернэт хэрэглэгчийн тооны нийлбэртэй тэнцүү байна

МӨРИЙН ДУГААР:112 Сумын хэрэглэгчийн тоо нь сумуудын интернэт хэрэглэгчийн тооны нийлбэртэй тэнцүү байна. Сумын хэрэглэгчид аймгийн төвийн хэрэглэгчийг оруулахгүй.

Аймгийн төв болон сумын хэрэглэгчийн тооны нийлбэр нь орон нутгийн хэрэглэгчийн тоо болно

МӨРИЙН ДУГААР:115 256 кбит/с-2 Мбит/с хурдтай хэрэглэгч гэдэгт 2 Мбит/с-ээс бага ба 256 кбит/с-ээс их эсвэл тэнцүү татах (downstream) хурдаар суурин интернэтийн үйлчилгээ авч буй хэрэглэгчийг хамруулна. *Энэ үзүүлэлт нь ОУЦХБ-ын “i4213_256to2” үзүүлэлттэй тохирно.*

МӨРИЙН ДУГААР:116 2 Мбит/с- 10 Мбит/с хэрэглэгч гэдэгт 10 Мбит/с-ээс бага ба 2 Мбит/с-ээс их эсвэл тэнцүү татах (downstream) хурдаар суурин интернэтийн үйлчилгээ авч буй хэрэглэгчийг хамруулна. *Энэ үзүүлэлт нь ОУЦХБ-ын “i4213_2to10” үзүүлэлттэй тохирно.*

МӨРИЙН ДУГААР:117 10 Мбит/с- 30 Мбит/с хэрэглэгч гэдэгт 30 Мбит/с-ээс бага ба 10 Мбит/с-ээс их эсвэл тэнцүү татах (downstream) хурдаар суурин интернэтийн үйлчилгээ авч буй хэрэглэгчийг хамруулна. *Энэ үзүүлэлт нь ОУЦХБ-ын “i4213_10to30” үзүүлэлттэй тохирно.*

МӨРИЙН ДУГААР:118 30 Мбит/с- 50 Мбит/с хэрэглэгч гэдэгт 50 Мбит/с-ээс бага ба 30 Мбит/с-ээс их эсвэл тэнцүү татах (downstream) хурдаар суурин интернэтийн үйлчилгээ авч буй хэрэглэгчийг хамруулна.

МӨРИЙН ДУГААР:119 50 Мбит/с- 100 Мбит/с хэрэглэгч гэдэгт 100 Мбит/с-ээс бага ба 50 Мбит/с-ээс их эсвэл тэнцүү татах (downstream) хурдаар суурин интернэтийн үйлчилгээ авч буй хэрэглэгчийг хамруулна. *118 ба 119 дугаар мөрийн дүнгийн нийлбэр нь ОУЦХБ-ын “i4213_30to100” үзүүлэлттэй тохирно.*

МӨРИЙН ДУГААР:120 100 Мбит/с- 1 Гбит/с хэрэглэгч гэдэгт 1 Гбит/с-ээс бага ба 100 Мбит/с-ээс их эсвэл тэнцүү татах (downstream) хурдаар суурин интернэтийн үйлчилгээ авч буй хэрэглэгчийг хамруулна. *Энэ үзүүлэлт нь ОУЦХБ-ын “i4213_100to1G” үзүүлэлттэй тохирно.*

МӨРИЙН ДУГААР:121 1 Гбит/с тэй тэнцүү болон түүнээс дээш хурдтай хэрэглэгч гэдэгт 1 Гбит/с-ээс их эсвэл тэнцүү татах (downstream) хурдаар суурин интернэтийн үйлчилгээ авч буй хэрэглэгчийг хамруулна. *Энэ үзүүлэлт нь ОУЦХБ-ын “i4213_G1Gb” үзүүлэлттэй тохирно.*

МӨРИЙН ДУГААР:122 Яриа, интернэтийн багцын үйлчилгээний идэвхтэй хэрэглэгчийн тоог багцын үйлчилгээний идэвхтэй хэрэглэгчийн тоог бичнэ.

Багцын үйлчилгээ нь хэрэглэгчийн хэрэгцээнд үндэслэн олон төрлийн холбооны үйлчилгээг нэгтгэн тусгай төлбөрт үйлчилгээг санал болгодог.

МӨРИЙН ДУГААР:123 Дан ярианы үйлчилгээний идэвхтэй хэрэглэгчийн тоог дан ярианы үйлчилгээний идэвхтэй хэрэглэгчийн тоог бичнэ.

МӨРИЙН ДУГААР:124 Дан интернэт үйлчилгээний идэвхтэй хэрэглэгчийн тоог дан интернэтийн үйлчилгээний идэвхтэй хэрэглэгчийн тоог бичнэ.

ХЭРЭГЛЭЭ, АЧААЛАЛ

МӨРИЙН ДУГААР:125-129 Ярианы ачаалал мөрөнд Тайлант хугацаанд хэрэглэгчийн ярьсан ярианы минутыг тохирох чиглэл, төрлөөр гаргаж нөхнө.

МӨРИЙН ДУГААР:130 Нийт түрээсэлж буй интернэтийн гадаад урсгалын хэмжээ мөрөнд бөөний интернэтийн үйлчилгээ үзүүлэгчдээс түрээсэлж буй нийт интернэт урсгалын хэмжээг нөхнө.

МӨРИЙН ДУГААР:131 Дотоодын интернэт харилцан холболтын төвд холбогдсон урсгалын хэмжээ мөрөнд Монгол Улсын дотор интернэт харилцан холболтын төвүүдэд (MIX) холбогдсон бол тэдгээрт холбогдсон нийт урсгалын хэмжээг нөхнө.

МӨРИЙН ДУГААР:132 Нийт сансрын холбооны өргөн зурвасын интернэт ачаалал мөрөнд (download + upload) тайлант хугацаанд нийт хэрэглэгчдийн үүсгэсэн интернэт ачааллыг (Гбайт) эцсийн хэрэглэгчийн цэгт (at the end-user access point) хэмжсэн дүнг нөхнө. Нарийн хэмжилт хийх боломжгүй тохиолдолд тооцооллын дүн байж болно. Интернэт ачаалалд Walled garden (including zero-rated) ачааллыг оруулахгүй.

Нийт ачаалал буюу 132 дугаар мөрийн дүн нь 133-аас 134 дүгээр мөрийн татах (download) болон илгээх (upload) хурдын нийлбэр дүнтэй тэнцүү байна.

Нийт интернэт ачааллыг интернэтэд хандсан логуудын бичлэг эсхүл дэлгэрэнгүй IP бичлэгүүд (IPDR-IP detail records)-ийн мэдээллийг ашиглаж гаргана. Эдгээр логууд нь хэрэглэгчийн интернэт хандалт бүрийн бүртгэл, ашигласан дата хэмжээний мэдээллийг агуулдаг.

Хэмжих боломжгүй тохиолдолд бөөний интернэтийн үйлчлэгчтэй солилцсон нийт ачааллын хэмжээ (volume), эсхүл бөөний интернэтийн түвшинд холбогдсон сувгийн дундаж ачаалал зэрэг тооцооллын дүн байж болно. Интернэт ачааллыг хэмжиж бус тооцоолж гаргасан бол тайлбар хэсэгт хэрхэн тооцсон болохыг заавал дурдана.

Өргөн зурвасын интернэт ачаалал гэж 256 кбит/с-тэй тэнцүү эсвэл түүнээс өндөр татах хурдаар суурин интернэтэд холбогдсон хэрэглэгчдийн үүсгэсэн ачааллыг хэлнэ.

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАРЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Сансрын холбооны сүлжээний бэлэн байдлыг (network availability) тайлант хугацаанд гэмтэлгүй ажилласан нийт хугацааг, нийт ажиллах ёстой хугацаанд харьцуулж гаргана. Гэмтэл гэж тодорхой шалтгааны улмаас хэрэглэгч үйлчилгээ авах боломжгүй болсон нөхцөл байдлыг ойлгоно. Үүнд хэрэглэгчийн буруугаас шалтгаалсан хэрэглэгчийн төхөөрөмж, гэр доторх дотоод сүлжээний гэмтэл болон төлөвлөгөөт засвар үйлчилгээний түр саатлыг оруулж тооцохгүй.

МӨРИЙН ДУГААР:136 Нийт гэмтлийн тоо мөрөнд тайлант хугацаанд систем, сүлжээнд гарсан нийт гэмтлийн тоог нөхнө.

МӨРИЙН ДУГААР:137 Гэмтлийн үргэлжилсэн нийт хугацаа мөрөнд тайлант хугацаанд суурь болон хэрэглэгчийн сүлжээ, системд гарсан нийт гэмтэл саатлын хугацааг бичнэ. *137 дугаар мөрийн дүн нь 138-аас 141 дүгээр мөрүүдийн нийлбэр дүнтэй тэнцүү байна.*

МӨРИЙН ДУГААР:142 Гэмтэл засварласан дундаж хугацаа мөрөнд тайлант хугацаанд гарсан нийт гэмтэл саатлыг засварласан хугацааг нийт гэмтэл саатлын тоонд харьцуулж тооцно.

МӨРИЙН ДУГААР:143 Татаж авах дундаж чадамж (Download throughput) гэж нэг секундэд татаж авах дата хэмжээг битээр (in bits) илэрхийлснийг хэлнэ. Нийт дамжуулсан дата хэмжээг (in bits) дамжуулсан хугацаанд харьцуулж тооцно.

МӨРИЙН ДУГААР:144 Илгээх дундаж чадамж (Upload throughput) гэж нэг секундэд илгээх дата хэмжээг битээр (in bits) илэрхийлснийг хэлнэ. Нийт илгээсэн дата хэмжээг (in bits) илгээсэн хугацаанд харьцуулж тооцно.

МӨРИЙН ДУГААР:145 Пакетын хоцрогдол (Latency) гэж пакет улсын дотор хүрэх ёстой цэгтээ очоод эхэлсэн цэгт буцаж ирэх хугацааг хэлнэ. Нийт хэмжсэн пакетын хоцрогдлуудын нийлбэрийг нийт тестийн тоонд харьцуулж тооцно.

МӨРИЙН ДУГААР:146 Хэрэглэгчийн гэрээлсэн хурдны хэмжээ оргил ачааллын цагт үзүүлэлтийг тооцохдоо тайлант хугацааны оргил цагуудын дундаж үзүүлэлтийг авна.

МӨРИЙН ДУГААР:147 Улс хоорондын зурвасын ашиглалт үзүүлэлтийг тооцохдоо тайлант хугацааны сар бүрийн хамгийн их утгуудын дундаж үзүүлэлтийг авна.

МӨРИЙН ДУГААР:148 Ярианы үйлчилгээний амжилтгүй дуудлагын эзлэх хувь (unsuccessful call ratio) Тайлант хугацаанд амжилтгүй болсон сансрын холбооны ярианы үйлчилгээний дуудлагыг нийт дуудлага хийх оролдлогын тоонд харьцуулж гаргана.

ГОМДЛЫН ҮЗҮҮЛЭЛТ

МӨРИЙН ДУГААР:149 Хэрэглэгчээс ирүүлсэн нийт гомдлын тоог тооцохдоо тайлант хугацаанд хүлээн авсан сансрын холбооны үйлчилгээтэй холбоотой бүх гомдлыг гомдлын хүчинтэй эсэх, сэдвээс үл хамааран багтаасан байна. Нэг хэрэглэгч нэг сэдвээр нэгээс илүү гомдол гаргах тохиолдолд гомдлын тохиолдол тус бүрийг тусад нь тоолно. Хэрэв үйлчлүүлэгч одоо байгаа гомдлыг хаахаас өмнө дахин гомдол гаргавал түүнийг тусдаа гомдол гэж үзэхгүй, харин эхний хаагдаагүй гомдлын үргэлжлэл гэж үзнэ. Гомдлын төрлөөр задалж, харгалзах мөрөнд бичнэ. *149 дүгээр мөрийн дүн нь 150-аас 157 дугаар мөрүүдийн нийлбэр дүнтэй тэнцүү байна.*

МӨРИЙН ДУГААР:158 Хэрэглэгчийн гомдлыг шийдвэрлэсэн дундаж хугацааг тооцохдоо тайлант хугацаанд хэрэглэгчээс ирүүлсэн нийт гомдлыг шийдвэрлэсэн хугацааны нийлбэрийг нийт шийдвэрлэсэн гомдлын тоонд харьцуулж тооцно.

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРОО

Зах зээл, үнэ тарифын зохицуулалтын газар

Зах зээлийн судалгаа шинжилгээний хэлтэс

Утас: 11-304258

МОНГОЛ УЛСЫН ХОТ, АЙМАГ, ДҮҮРЭГ СУМ, ХОРОО БАГИЙН КОД

Архангай аймаг	65	Баян-Өлгий аймаг	83	Булган аймаг	63	Баянхонгор аймаг	64
Эрдэнэбулган	01	Өлгий	01	Булган	01	Баянхонгор	01
Батцэнгэл	04	Алтай	04	Баян-Агт	04	Баацагаан	04
Булган	07	Алтанцөгц	07	Баяннуур	07	Баянбулаг	07
Жаргалант	10	Баяннуур	10	Бугат	10	Баянговь	10
Ихтамир	13	Бугат	13	Бүрэгхангай	13	Баянлиг	13
Өгийнуур	16	Булган	16	Гурванбулаг	16	Баян-Овоо	16
Өлзийт	19	Буянт	19	Дашинчилэн	19	Баян-Өндөр	19
Өндөр-Улаан	22	Дэлүүн	22	Могод	22	Баянцагаан	22
Тариат	25	Ногооннуур	25	Орхон	25	Богд	25
Төвшрүүлэх	28	Сагсай	28	Рашаант	28	Бөмбөгөр	28
Хайрхан	31	Толбо	31	Сайхан	31	Бууцагаан	31
Хангай	34	Улаанхус	34	Сэлэнгэ	34	Галуут	34
Хашаат	37	Цагааннуур	37	Тэшиг	37	Гурванбулаг	37
Хотонт	40	Цэнгэл	40	Хангал	40	Жаргалант	40
Цахир	43			Хишиг-Өндөр	43	Жинст	43
Цэнхэр	46	Дорноговь аймаг	44	Хутаг-Өндөр	46	Заг	46
Цэцэрлэг	49	Сайншанд	01			Өлзийт	49
Чулуут	52	Айраг	04	Дархан-Уул аймаг	45	Хүрээмарал	52
Эрдэнэмандал	55	Алтанширээ	07	Дархан	01	Шинэжинст	55
		Даланжаргалан	10	Орхон	04	Эрдэнэцогт	58
		Дэлгэрэх	13	Хонгор	07		
Говь-Алтай аймаг	82	Замын-Үүд	16	Шарын гол	10	Завхан аймаг	81
Есөнбулаг	01	Иххэт	19			Улиастай	01
Алтай	04	Мандах	22	Дундговь аймаг	48	Алдархаан	04
Баян-Уул	07	Өргөн	25	Сайнцагаан	01	Асгат	07
Бигэр	10	Сайхандулаан	28	Адаацаг	04	Баянтэс	10
Бугат	13	Улаанбадрах	31	Баянжаргалан	07	Баянхайрхан	13
Дарви	16	Хатанбулаг	34	Говь-Угтаал	10	Дөрвөлжин	16
Дэлгэр	19	Хөвсгөл	37	Гурвансайхан	13	Завханмандал	19
Жаргалан	22	Эрдэнэ	40	Дэлгэрхангай	16	Идэр	22
Тайшир	25			Дэлгэрцогт	19	Их Уул	25
Тонхил	28	Дорнод аймаг	21	Дэрэн	22	Нөмрөг	28
Төгрөг	31	Хэрлэн	01	Луус	25	Отгон	31
Халиун	34	Баяндун	04	Өлзийт	28	Сантмаргац	34
Хөхморьт	37	Баянтүмэн	07	Өндөршил	31	Сонгино	37
Цогт	40	Баян-Уул	10	Сайхан-Овоо	34	Тосонцэнгэл	40
Цээл	43	Булган	13	Хулд	37	Түдэвтэй	43
Чандмана	46	Гурванзагал	16	Цагаандэлгэр	40	Тэлмэн	46
Шарга	49	Дашбалбар	19	Эрдэнэдалай	43	Тэс	49
Эрдэнэ	52	Матад	22			Ургамал	52
		Сэргэлэн	25	Орхон аймаг	61	Цагаанхайрхан	55
Говьсүмбэр аймаг	42	Халхгол	28	Баян-Өндөр	01	Цагаанчулуут	58
Сүмбэр	01	Хөлөнбуйр	31	Жаргалант	04	Цэцэн-Уул	61
Баянтал	04	Цагаан-Овоо	34			Шилүүстэй	64
Шивээговь	07	Чойбалсан	37			Эрдэнэхайрхан	67
		Чулуунхороот	40			Яруу	70

Өвөрхангай аймаг	62	Өмнөговь аймаг	46	Сэлэнгэ аймаг	43	Хэнтий аймаг	23
Арвайхээр	01	Даланзадгад	01	Сүхбаатар	01	Хэрлэн	01
Баруун Баян-Улаан	04	Баяндалай	04	Алтанбулаг	04	Батноров	04
Бат-Өлзий	07	Баян-Овоо	07	Баруунбүрэн	07	Батширээт	07
Баянгол	10	Булган	10	Баянгол	10	Баянадрага	10
Баян-Өндөр	13	Гурвантэс	13	Ерөө	13	Баянмөнх	13
Богд	16	Мандал-Овоо	16	Жавхлант	16	Баян-Овоо	16
Бүрд	19	Манлай	19	Зүүнбүрэн	19	Баянхутаг	19
Гучин ус	22	Ноён	22	Мандал	22	Биндэр	22
Зүйл	25	Номгон	25	Орхон	25	Галшир	25
Зүүн Баян Улаан	28	Сэврэй	28	Орхонтуул	28	Дадал	28
Нарийн тээл	31	Ханбогд	31	Сайхан	31	Дархан	31
Өлзийт	34	Ханхонгор	34	Сант	34	Дэлгэрхаан	34
Сант	37	Хүрмэн	37	Түшиг	37	Жаргалтхаан	37
Тарагт	40	Цогт-Овоо	40	Хүдэр	40	Мөрөн	40
Төгрөг	43	Цогтцэций	43	Хушаат	43	Норовлин	43
Уянга	46			Цагааннуур	46	Өмнөдэлгэр	46
Хайрхандулаан	49	Сүхбаатар аймаг	22	Шаамар	49	Цэнхэрмандал	49
Хархорин	52	Баруун-Урт	01				
Хужирт	55	Асгат	04	Увс аймаг	85	Хөвсгөл аймаг	67
		Баяндэлгэр	07	Улаангом	01	Мөрөн	01
Төв аймаг	41	Дарьганга	10	Баруунтуруун	04	Алаг-Эрдэнэ	04
Зуунмод	01	Мөнххаан	13	Бөхмөрөн	07	Арбулаг	07
Алтанбулаг	04	Наран	16	Давст	10	Баянзүрх	10
Аргалант	07	Онгон	19	Завхан	13	Бүрэнтогтох	13
Архуст	10	Сүхбаатар	22	Зүүнговь	16	Галт	16
Батсүмбэр	13	Түвшинширээ	25	Зүүнхангай	19	Жаргалант	19
Баян	16	Түмэнцогт	28	Малчин	22	Их-Уул	22
Баяндэлгэр	19	Уулбаян	31	Наранбулаг	25	Рашаант	25
Баянжаргалан	22	Халзан	34	Өлгий	28	Ренчинлхүмбэ	28
Баян-Өнжүүл	25	Эрдэнэцагаан	37	Өмнөговь	31	Тариалан	31
Баянхангай	28			Өндөрхангай	34	Тосонцэнгэл	34
Баянцагаан	31	Ховд аймаг	84	Сагил	37	Төмөрбулаг	37
Баянцогт	34	Жаргалант	01	Тариалан	40	Түнэл	40
Баянчандмана	37	Алтай	04	Түргэн	43	Улаан-Уул	43
Борнуур	40	Булган	07	Тэс	46	Ханх	46
Бүрэн	43	Буянт	10	Ховд	49	Цагааннуур	49
Дэлгэрхаан	46	Дарви	13	Хяргас	52	Цагаан-Уул	52
Жаргалант	49	Дөргөн	16	Цагаанхайрхан	55	Цагаан-Үүр	55
Заамар	52	Дуут	19			Цэцэрлэг	58
Лүн	55	Зэрэг	22	Улаанбаатар хот	11	Чандмана-Өндөр	61
Мөнгөнморьт	58	Манхан	25	Багануур	01	Шинэ-Идэр	64
Өндөрширээт	61	Мөнххайрхан	28	Багахангай	04	Эрдэнэбулган	67
Сүмбэр	64	Мөст	31	Баянгол	07		
Сэргэлэн	67	Мянгад	34	Баянзүрх	10		
Угтаалцайдам	70	Үенч	37	Налайх	13		
Цээл	73	Ховд	40	Сонгинохайрхан	16		
Эрдэнэ	76	Цэцэг	43	Сүхбаатар	19		
Эрдэнэсант	79	Чандмана	46	Хан-Уул	22		
		Эрдэнэбүрэн	49	Чингэлтэй	25		